

## Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

2023 онд Соёл урлагийн газар нь 12 чиглэлийн танхимын болон цахим сургалт, Дээд шатны болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан 30 удаагийн сургалтад давхардсан тоогоор 553 албан хаагчийг хамруулсан. Төрийн захиргааны, ахлах түшмэлийн багц сургалтад-1, төрийн албаны чиглүүлэх сургалтад-2 албан хаагчийг тус тус сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүллээ. 2024 онд Соёлын яамтай хамтран хойд бүсийн салбарын ажилтны зөвлөгөөнд 135 албан хаагч, Соёлын өвийн сургалтад Соёлын төв, ордон, Музейн 18 албан хаагч, Статистикийн мэдээ гаргах сургалтад 21 байгууллагын 42 албан хаагч, дотоод хяналт хэрэгжүүлэх сургалтад 21 байгууллагын 22 албан хаагч, Удирдах ажилтны улсын зөвлөгөөнд 20 удирдах албан хаагч, номын сангийн цахим системийн сургалтад Нийтийн номын сангийн 2 ажилтан, Музей, Нийтийн номын сангийн захирлуудыг Соёлын яамнаас зохион байгуулсан сургалтад тус тус хамруулсан. Мөн Соёлын салбарын нийт албан хаагчдыг Соёлын яамнаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн цахим сургалтад хамруулсан. /Давхардсан тоогоор 415 хүн хамрагдсан/

2024 оны 9 сарын байдлаар Аймгийн соёлын салбарт ажиллаж буй 170 ажилтнаас 68.2 хувь буюу 116 нь мэргэжлийн ажилтан байна. Соёлын байгууллагуудад ажиллаж буй мэргэжлийн бус 54 ажилтнаас 9 ажилтныг СУИС-д эчнээгээр суралцахад дэмжлэг үзүүлэн суралцуулж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар соёлын салбарын мэргэжлийн хүний нөөц 58.0 хувьтай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар мэргэжлийн хүний нөөцийн хангалт 65.5 хувь болж, өмнөх оноос 7.5 хувь, 2024 онд 68.2 хувьд хүрч 2.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Соёлын байгууллагад ажиллаж буй мэргэжлийн бус ажилтнуудыг мэргэжил эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байдал /2023, 2024 он/			
№	Сум	Овог, Нэр	Сургууль
1	Могод сум	Х.Жүгдэрхорол	СУИС /эчнээ/
2	Гурванбулаг	Б.Сарангэрэл	СУИС /эчнээ/
3	Номын сан	Г.Энхбилэг	СУИС /эчнээ/
4	Номын сан	Д.Отгонцэцэг	СУИС /эчнээ/
5	Номын сан	Д.Мөнхгэрэл	СУИС /эчнээ/
6	Номын сан	Б.Ариужаргал	СУИС /эчнээ/
7	ХЖТ	Д.Ганцогт	СУИС /эчнээ/
8	Баян-Агт	Д.Алимаа	СУИС /эчнээ/
9	Баян-Агт	Ж.Алтансүх	СУИС /эчнээ/

## 2022, 2023, 2024 оны хүний нөөцийн өссөн дүн:



**Соёлын салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд:**

2022, 2024 онд Соёл урлагийн их сургуулийн элсэлтийн сонгон шалгаруулалтыг аймагтаа хамтран зохион байгуулж нийт 2022 онд СУИС болон Монгол Улсын Консерватори-д 12, 2024 онд СУИС-д 9 оюутан элсүүлсэн.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТЭТГЭЛЭГ АВСАН СУРАГЧДЫН ЖАГСААЛТ**

2023 он				
№	Сум, Сургууль	Овог, Нэр	Сургууль	Мэргэжил
1	Хутаг-Өндөр сум ЕБС	Э.Эрдэнэбат	СУИС-Бүжгийн урлагийн сургууль	Бүжигчин
2	Хутаг-Өндөр сум ЕБС	Э.Ангараг	СУИС-Бүжгийн урлагийн сургууль	Бүжигчин
3	Булган сум 1-р сургууль	О.Хүслэн	СУИС-Бүжгийн урлагийн сургууль	Бүжигчин
4	Булган сум 1-р сургууль	М.Маралмаа	СУИС-Бүжгийн урлагийн сургууль	Бүжигчин
5	Сэлэнгэ сум ЕБС	Ц.Алтанцэцэг	СУИС-Бүжгийн урлагийн сургууль	Бүжигчин
6	Булган сум 1-р сургууль	М.Солонго	Сити их сургууль	Дуу хөгжмийн багш
2024 он				
1	Булган сум 1-р сургууль	О.Халиун	СУИС-Бүжгийн урлагийн сургууль	Бүжигчин
2	Рашаант сум ЕБС	О.Итгэл	СУИС-Хөгжмийн урлагийн сургууль	Хөгжимчин, концертмейстер
3	Булган сум, ХЖТ	Н.Наранбаатар	СУИС-Радио телевиз медиа урлагийн сургууль	Дуу чимээний технологич
4	Булган сум 1-р сургууль	Ш.Энхмаа	СУИС-Хөгжмийн урлагийн сургууль	Хөөмийч, лимбэчин
5	Дашинчилэн сум ЕБС	Ц.Насанжаргал	СУИС-Хөгжмийн урлагийн сургууль	Хөгжимчин/шанз/

2023 онд 28 сая төгрөгийн аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон.

2024 онд 22 сая төгрөгийн аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон.

Холбогдох дээд шатны байгууллагуудад хүсэлт уламжилж соёлын төвүүдийн нягтлан бодогчийн 40 хувийн нэмэгдлийг шийдвэрлүүлж соёлын байгууллагуудад 5 жил тасралтгүй ажиллаж хуулийн дагуу тэтгэмж авах шалгуурыг хангасан ажиллагсдын шаардагдах мэдээлэл мөнгөн дүнг 2023 оны төсвийн төсөлд тусган Соёлын яаманд хүргүүлсэн бөгөөд тэтгэмж олгох журам батлагдаж журмын дагуу олгосон. Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд 2023 онд Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хандив тусламж, бусад эх үүсвэрээс 432.3 сая төгрөгийг шийдвэрлүүлж шаардлагатай тавилга эд хогшил, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг,

2024 онд Улсын төсвийн 153 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурин болон зөөврийн компьютер принтер нийлүүлсэн.

Монгол Улсын Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09 өдрийн А/390 дүгээр тушаалаар баталсан "Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"-ын дагуу Үр дүнгийн нэмэлт санхүүжилтээс албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 15%-ийг, ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгоход 15%-ийг олгохоор шийдвэрлсэн.

### 2023 онд үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт:

Соёлын байгууллагын нийт 100 албан хаагчийн Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 23.5 сая.төгрөг, 75 албан хаагчид 23.8 сая.төгрөгийн урамшуулал олгосон.

### 2023 онд үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт:

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв /Албан хаагчдын нийгмийн баталгаа-213204/	Гүйцэтгэл /Албан хаагчдын нийгмийн баталгаа-9-р сарын байдлаарх гүйцэтгэл/
1	Баян-Агт соёлын төв	1,225,000.00	0
2	Бугат соёлын төв	944,400.00	600,000.00
3	Бүрэгхангай соёлын төв	574,700.00	0
4	Гурванбулаг соёлын төв	906,700.00	0
5	Дашинчилэн соёлын төв	853,000.00	0.00
6	Могод соёлын төв	1,414,600.00	1,414,600.00
7	Орхон соёлын төв	791,100.00	0.00
8	Сайхан соёлын төв	728,900.00	0.00
9	Сэлэнгэ соёлын төв	1,074,400.00	0.00
10	Тэшиг соёлын төв	979,500.00	0.00
11	Хангал соёлын төв	750,500.00	0.00
12	Хишиг-Өндөр соёлын төв	1,248,200.00	0.00
13	Хутаг-Өндөр соёлын төв	1,225,000.00	0.00
14	Булган сум Соёлын ордон	1,136,200.00	0.00
15	Баяннуур Соёлын төв	749,800.00	0.00
16	Рашаант Соёлын төв	1,128,600.00	0.00
17	Хялганат тосгон Соёлын төв	1,180,800.00	1,180,700.00
18	Хөгжимт жүжгийн театр	8,353,200.00	8,353,200.00
19	Музей	3,367,300.00	0.00
20	Номын сан	3,837,700.00	3,834,000.00
		<b>32,469,600.0</b>	<b>15,382,500.0</b>

### Соёл урлагийн байгууллагуудад шилжин сууршин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих хүрээнд:

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Хот хөдөөгийн сэргэлт" аян "VISIT BULGAN" арга хэмжээний үеэр болон Аймагт зохион байгуулагдсан "Хөрөнгө оруулагчдын чуулган" "Нээлттэй Булган-Ээлтэй нутаг" өдөрлөгийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлан соёлын салбарын онцлог, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сул орон тооны мэдээллийг оюутан залуучууд, иргэд олон нийтэд хүргэж мэдээлэл сурталчилгаа хийсэн. 4 сумын Соёлын төв /Бугат, Рашаант, Орхон, Сэлэнгэ/ шилжин сууршин ажиллах иргэдийг орон байраар хангах нөхцөлийг бүрдүүлсэн. 2023 онд Бугат сумын Соёлын төв шилжин ирж ажилласан 1 иргэнийг, 2024 онд Бугат, Сайхан сумын соёлын төв шилжин ирж ажилласан 2 иргэнийг орон байраар хангасан.

### Соёл урлагийн газрын нийт албан хаагчийн Нийгмийн баталгааг хангахад зарцуулсан төсөв:

2022 онд 9 албан хаагч 11.154 сая.төгрөг

2023 онд 9 албан хаагч 25.211 сая.төгрөг

2024 онд 12 албан хаагч 11.510 сая төгрөг

**Тайлбар:**

- *Онуудын мөнгөн дүнг сольж өгсөн байна.*
- *2023 онд өндөр байгаа нь 13 сарын цалин бодогдсон*